

НИЙСЛЭЛИЙН ҮЙЛДВЭР, ХӨДӨӨ АЖ АХУЙН ГАЗАР

2015 ОНЫ 08 ДУГААР САРЫН 10-НЫ ӨДРИЙН НИЙСЛЭЛИЙН
УДИРДАХ АЖИЛТНУУДЫН ШУУРХАЙ ЗӨВЛӨГӨӨНД ӨГСӨН ҮҮРЭГ ДААЛГАВРЫН БИЕЛЭЛТ

№	Өгсөн үүрэг даалгавар	Үүрэг даалгаврын дагуу хийж гүйцэтгэсэн үйл ажиллагаа	Хүрсэн бодит үр дүн / түүнийг нотлох нотолгоо/	Үүрэг даалгавар биелэ эгүй бол хэрэг жээгү й шалтгаан	Цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээ	Үнэлгээ 0-100
1	Нийслэлийн хэмжээнд төмс, хүнсний ногоог нөөцлөх агуулах, зоорийн хэвийн нөхцөлийг хангуулах, хадлан тэжээл бэлтгэх ажлыг зохион байгуулах.	Засгийн газраас 2015 оны 07 дугаар сарын 07-ны өдөр “Мал аж ахуйн салбарын 2015-2016 оны өвөлжилтийн бэлтгэл ажил хангах зарим арга хэмжээ”-ний тухай 292 дугаар тогтоолыг баталсны дагуу Нийслэлийн засаг даргын 01 тоот албан даалгаврыг мал бүхий дүүргүүдийн удирдлагад 7 дугаар сарын 27-ны өдөр хүргүүлж, биелэлтийг хангуулахаар ажиллаж байна. Мал бүхий дүүргүүдэд аюулгүйн нөөцөд бүрдүүлэх өвс тэжээлийн хэмжээг тооцон хүргүүлсэн ба Нийслэлийн Онцгой байдлын хэлтэс болон дүүргээс санал авч, нэгтгэн өвөлжилтийн бэлтгэл хангах ажлын төлөвлөгөөг боловсруулаа. Нийслэлийн хэмжээнд 270 сая төгрөгийн аюулгүйн нөөц бүрдүүлэхээс, мал бүхий дүүргүүдээс өөрсдийн нөөцөөр 120 сая төгрөгийн өвс, тэжээл бэлтгэх боломжтой бөгөөд нийслэлээс 150 сая төгрөгийн	Зах зээлийн ханшаар нэг тонн өвс 250 мянга, нэг тонн тэжээл 500 мянган төгрөгийн ханштай байна. Багануур, Хан-Уул, Баянзүрх дүүргээс хадлан бэлтгэх газар нутаг, техник тоног төхөөрөмж дутагдалтай. Налайх дүүргээс "Алтан тариа"-ХХК-н тэжээлийн үнэ нэмж байгааг тогтвортой байлгах талаар арга хэмжээ авах, Багануур, Хан-Уул, Баянзүрх дүүрэг өвс, тэжээл хадгалах агуулах, саравч хэрэгтэй байгаа зэрэг асуудлыг шийдвэрлүүлэхээр саналаа ирүүлсэн. Нийслэлийн хэмжээнд бороо багатай, гандуу байсан нь хадлан бэлтгэхэд хүндрэл үүсгэж дүүргүүдийн хэмжээнд өвс тэжээлийн нөөц бүрдүүлэх санхүүгийн эх үүсвэр муу, өвс, тэжээлийг хадгалах, агуулах савгүй, хадлан бэлтгэх талбай жил бүр багасаж, отрын бэлчээр, нутаггүй болж байгаа зэрэг нийтлэг бэрхшээлтэй асуудлууд байна.		Оторлох боломжтой аймаг сумтай гэрээ байгуулах, бага оврын трактор зээлээр олгох зэрэг ажлыг “Мал аж ахуйн салбарын 2015-2016 оны өвөлжилтийн бэлтгэл ажил хангах төлөвлөгөө”-ний төсөлд тусган боловсруулж, Нийслэлийн удирдлагын	50

		санхүүжилт нэмж гаргах зайлшгүй шаардлагатай тооцоо гарч байна. Нийслэлийн Засаг даргын захирамжийн төслийг боловсрууллаа.			зөвлөлийн хуралдаанаар хэлэлцүүлэхээр бэлтгэж байна.	
2		2013 оны байдлаар нийслэлийн хэмжээнд зоорийн багтаамж 63,4 мянган тонн байгаа ба 2016 онд 129,9 мянган тонн болгохоор зорилт тавин ажиллаж байна. Монгол банкны Ерөнхийлөгч, Үйлдвэр, хөдөө аж ахуйн сайдын хамтарсан “Улаанбаатар хот орчимд хүнсний бүтээгдэхүүний төрөлжсөн зоорь, агуулах, махны дагнасан болон төрөлжсөн бөөний, жижиглэн худалдааны төв шинээр байгуулах, өргөжүүлэх” чиглэлээр зарлагдсан төсөлд 27 аж ахуйн нэгж шалгарч, 74,9 тэрбум төгрөгийн зээл авснаар төмс, хүнсний ногооны зоорь 66,5 мянган тонноор буюу зоорийн багтаамж 37 хувиар нэмэгдэхээр байгаа. 2015 оны байдлаар зоорийн багтаамж 22,3 мянган тонноор нэмэгдэж 85,7 мянган тонн болсон байна. Энэ жилийн хураан авах ургацын баланс гараагүй байгаа учир ургацын хичнээн хувийн хадгалах нь тодорхойгүй байна.	Монголбанкны Ерөнхийлөгч, Үйлдвэр, хөдөө аж ахуйн сайдын хамтарсан А-166/А-24 дугаартай тушаалаар батлагдсан “Хүнсний гол нэрийн бараа, бүтээгдэхүүний үнийг тогтворжуулах” дэд хөтөлбөрүүдийн хэрэгжилтийг хангах хүрээнд “Улаанбаатар хот орчимд хүнсний бүтээгдэхүүний төрөлжсөн зоорь, агуулах, махны дагнасан болон төрөлжсөн бөөний, жижиглэн худалдааны төв шинээр байгуулах, өргөжүүлэх” төсөл зарлагдсан. 2015 оны байдлаар Тэнгэр ХХК 5000тн, "М Ти Эс" ХХК 7000, Траст трейд ХХК 1000, Мега үржих трейд ХХК 800тн, “Дельта холдинг” ХХК 8500тн-ын зоориуд ашиглалтанд шинээр орсон байна.		Хүнс Хөдөө Аж Ахуйн Яам, Нийслэлийн Мэргэжлийн Хяналтын Газартай хамтран 2015 оны ургац хураалт, зоорийн хангамж, нийлүүлэлт, төмс, хүнсний ногоо хүлээн авах бэлтгэл ажлыг шалгах ажлын удирдамж боловсруулж байна.	50